



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1-3.9 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн Төрийн албаны салбар зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллахыг Салбар зөвлөлийн гишүүдэд, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр танилцуулахыг Салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ц.Алтанцацралд үүрэг болгосугай.

ДАРГА

Chello Munkh Ц.МӨНХЗУЛ

УХА0115
67

Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны 01...дугаар сарын 16-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨРИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хариуцах гишүүн	Хамтран ажиллах байгууллага
1. Зохион байгуулалтын хүрээнд							
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах	Жилдээ	Салбар зөвлөлийн төлөвлөгөөний тоо; Тайлангийн тоо	0	1	С3-ийн дарга С3-ийн Нарийн бичгийн дарга	ТАЗ
2	Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр шинэчлэн байгуулах	2-3 дугаар сард	ТАЗ-ийн тогтоолын тоо	0	1	С3-ийн дарга С3-ийн Нарийн бичгийн дарга	ТАЗ
3	Салбарын байгууллагуудын хүний нөөцийн мэргэжилтнүүдэд төрийн албатай холбоотой хууль журам, стандартын хэрэгжилтийг ханган ажиллах талаар мэргэшил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Зөвлөгөө үзүүлсэн тоо	0	4	С3-ийн дарга С3-ийн Нарийн бичгийн дарга	Харьяа агентлаг, байгууллагууд
4	Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг, даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах	Жилдээ	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	0	Тухай бүр	С3-ийн Нарийн бичгийн дарга	Харьяа агентлаг, байгууллагууд
5	Эрх хэмжээний хүрээнд Салбар зөвлөлөөс хэлэлцсэн асуудлаар тогтоол батлан гаргах, тогтоолын хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон ажиллах	Жилдээ	Тогтоолын хэрэгжилтийн хувь	0	100%	Салбар зөвлөлийн гишүүд	
6	Төрийн албаны өдрийг угтан Монгол Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулах Төрийн албаны хаагчдын Үндэсний чуулганы зохион байгуулалтад оролцох	6 дугаар сард	Зохион байгуулсан чуулганы тоо	0	1	С3-ийн дарга С3-ийн Нарийн бичгийн дарга	ТАЗ
2. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх хүрээнд							
1	Салбарын байгууллагын албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хугацаанд нь шинэчлэх тухай агентлагуудын хүний нөөцийн асуудал харуулсан мэргэжилтнүүдэд үүрэг чиглэл өгч ажиллах, хяналт тавих	Жилдээ	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	0	100%	С3-ийн Нарийн бичгийн дарга	Яам, харьяа агентлаг, байгууллагууд

УХА0115
67

3. Маргаан хянан шалгах хүрээнд

Тухай бүр	Гомдол, маргаан шийдвэрлэлтийн хувь	0	100%	Салбар зөвлөлийн гишүүд
1 Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбоотой гарсан аливаа гомдол маргааныг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	0	100%	Салбар зөвлөлийн гишүүд
2 Иргэн, улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэхэд шаардлагатай мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	Тухай бүр	0	Тухай бүр	СЗ-ийн дарга СЗ-ийн Нарийн бичгийн дарга

4. Төрийн албаны шалгалт зохион байгуулах хүрээнд

Тухай бүр	Хяналтын тоо	0	10	СЗ-ийн дарга СЗ-ийн Нарийн бичгийн дарга
1 Яам болон харьяа агентлагуудын төрийн жинхэнэ албаны албан тушаалын сул орон тоо гарсан тухай бүрт нь Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын дагуу нийтэд зарласан эсэхэд хяналт тавин ажиллах	Тухай бүр	0	10	Яам, харьяа агентлаг, байгууллагууд
2 Яам болон харьяа агентлагуудын төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тухай бүрт нь байгууллагуудаас захиалга хүлээн авах	Жилдээ	0	10	Яам, харьяа агентлаг, байгууллагууд
3 Сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, холбогдох мэдээллээр төлөвлөгөө үүсгэх	Тухай бүр	0	10	СЗ-ийн дарга СЗ-ийн Нарийн бичгийн дарга
4 Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг Салбар зөвлөлийн хурлын тогтоолоор байгуулан ажиллуулах	Тухай бүр	1	10	Салбар зөвлөлийн гишүүд
5 Байгууллагуудын захиалгын дагуу сонгон шалгаруулалт явуулж, дүнг ТАСЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх, салбар зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах	Жилдээ	0	100%	Салбар зөвлөлийн гишүүд

6	Төрийн албаны тусгай шалгалтын Ярилцлагын хэсэгт техник технологийг нэвтрүүлэх ажлыг эхлэх	Жилдээ	Гүйцэтгэлийн хувь	0	50%	СЗ-ийн дарга СЗ-ийн Нарийн бичгийн дарга	ТАЗ
---	--	--------	-------------------	---	-----	---	-----

5. Хяналт тавих, аудит хийх хүрээнд

1	Зарим харьяа агентлаг, байгууллагад Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартын хэрэгжилттэй танилцах, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах	2 дугаар хагас жилд	Хяналт шалгалтын тоо	0	2	СЗ-ийн Нарийн бичгийн дарга	ХГБХХЕГ
2	Яамны харьяа төсвийн байгууллагуудад төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцон ажиллахыг үүрэг чиглэл болгож, арга зүйн удирдлагаар ханган ажиллах	Жилдээ	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	70%	СЗ-ийн дарга СЗ-ийн Нарийн бичгийн дарга	Яам, харьяа агентлаг, байгууллагууд

6. Сургалт судалгаа, сурталчилгаа хийх хүрээнд

1	ГБХНХЯ болон сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын Хүний нөөцийн ажилтнуудын туршлага харилцан солигдох өдөрлөг зохион байгуулах	Эхний хагас жилд	Өдөрлөг уулзалтын тоо	0	1	СЗ-ийн дарга СЗ-ийн Нарийн бичгийн дарга	Яам, харьяа агентлаг, байгууллагууд
2	Яамны цахим хуудсаар төрийн алба, албан хаагчтай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, зөвлөмж, холбогдох мэдээллүүдийг яамны цахим хуудаст байршуулж мэдээллээр хангах	Жилдээ	Мэдээлэлийн тоо	0	10	СЗ-ийн Нарийн бичгийн дарга	Яамны Хүний нөөцийн аажилтан
3	Харьяалах байгууллагуудын сул орон тооны судалгааг нэгтгэн гаргах	Жилдээ	Судалгааны тоо	0	2	СЗ-ийн Нарийн бичгийн дарга	Яам, харьяа агентлаг,

7. Хүний нөөцийн бодлогын хүрээнд

1	Шаардлагатай мэдээ, тайлан, судалгаа материалыг тухай бүр гаргуулан авч, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх	Жилдээ	Мэдээ, тайлангийн тоо	0	2	СЗ-ийн Нарийн бичгийн дарга	Яам, харьяа агентлаг, байгууллагууд
2	Төрийн захиргааны албан хаагчдаас болзол, шаардлага хангасан удирдах болон гүйцэтгэх албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшингийн үнэлгээг харгалзан холбогдох зэрэг дэвийг олгуулахаар материалыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж ажиллах	6,12 сард	Зэрэг дэв олгуулах шийдвэрийн тоо	0	2	СЗ-ийн дарга СЗ-ийн Нарийн бичгийн дарга	Яам, харьяа агентлаг, байгууллагууд

3	Төрийн жинхэнэ албан хаагчдын таанараг өргөх ёслолын үйл ажиллагаа зохион байгуулах	3,9,12 дугаар сард	Тангараг өргүүлэх үйл ажиллагаа зохион байгуулсан тоо	0	3	С3-ийн дарга С3-ийн Нарийн бичгийн дарга	Яам, харьяа агентлаг, байгууллагууд
4	Шагналын журмын болзол шаардлага хангасан төрийн албан хаагчийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулахаар нэр дэвшүүлж, материалыг ТА3-д хүргүүлэх	Тухай бүр	Шагналд тодорхойлох шийдвэрийн тоо	0	2	С3-ийн дарга С3-ийн Нарийн бичгийн дарга	Яам, харьяа агентлаг, байгууллагууд
5	Яам болон агентлагуудын орон тоо, чиг үүргийг шинэчлэн батлахтай холбоотойгоор төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шаардлагын дагуу хянан, Төрийн албаны зөвлөлд батлах зөвшөөрөл авах, санал авахаар хүргүүлэх	Жилдээ	Шинээр болон шинэчилсэн албан тушаалын тодорхойлолтын тоо	0	Тухай бүр	С3-ийн дарга С3-ийн Нарийн бичгийн дарга	Яам, харьяа агентлаг, байгууллагууд

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ